

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/2/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.23 № 102

танай _____ ны № _____ т

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.АЛТАНШАГАЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 0.5 сая төгрөгийн бараа материал, 45.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэн авсан байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант онд ахмадын сангийн хөрөнгийг зарцуулахдаа хорооны шийдвэргүй хоёр ахмадад 7.0 сая төгрөгийг шууд зарцуулсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

6326050019

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	67,247.84	100,126.74
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	499,871.65	457,834.73
	Нийт хөрөнгийн дүн	567,119.48	557,961.47
	Нийт өр төлбөрийн дүн	3,789.20	26,036.65
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	563,330.28	531,924.82
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	567,119.48	557,961.47
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	926,329.18	909,615.36
	Үйл ажиллагааны зардлын дүн	912,529.55	934,343.91
	Үйл ажиллагааны үр дүн	13,799.62	-24,728.55
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	-6,676.92
	Үйл ажиллагааны нийт үр дүн	13,799.62	-31,405.46
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	549,532.66	563,330.28
	Тайлант оны үр дүн	13,797.62	-31,405.46
	Эцсийн үлдэгдэл	563,330.28	531,924.82
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	869,538.34	862,432.76
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	843,206.84	874,463.76
	Үйл ажиллагааны ЦМГ	20.94	6.44
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	20.96	6.44
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	26,331.50	-12,031.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	12,031.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,031.00	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	774,359.10	751,307.87
	Урсгал зардал	774,359.10	751,307.87
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	720,101.70	788,389.04
	Улсын төсвөөс санхүүжих	660,101.70	690,122.20
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	60,000.00	98,266.84

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7,289.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 7,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж 289.2 мянган төгрөгийн 1 алдаа залруулан ажиллаа.

5.1 Төлбөрийн акт Байхгүй

5.2 Албан шаардлага Байхгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:1 Тайлант онд ахмадын сангийн хөрөнгөнөөс 2 ахмадад гадаад улс руу эмчилгээнд явахад 7,000.0 мянган төгрөгийг хорооны шийдвэргүй зарцуулсан.

Энэ нь “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 3.5 дахь ”Ахмадын сангаас дэмжлэг, тусламж авахыг хүссэн ахмад настан тухайн байгууллагын дэргэдэх ахмадын хороо, зөвлөлд хүсэлт гаргана.”, 3.6 дахь “Энэ журмын 3.5-д заасан хүсэлтийг тухайн

байгууллагын ахмадын хороо, зөвлөлийн албан ёсны саналыг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, төсвийн байгууллагын шууд захирагч шийдвэрлэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахмадын сангийн хөрөнгийг зарцуулахдаа ахмадын хорооны шийдвэрт үндэслэн шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл зөрүүтэй тайлагнасан	1	289.2			1	289.2	1	289.2				
Дүн	1	289.2			1	289.2	1	289.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд ахмадын сангийн хөрөнгөнөөс 2 ахмадад гадаад улс руу эмчилгээнд явахад 7,000.0 мянган төгрөгийг хорооны шийдвэргүй зарцуулсан.	1	7,000.0					1	7,000.0				
Дүн	1	7,000.0					1	7,000.0				